

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН 2017 ОНЫ ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

<b>№</b>	<b>Гүйцэтгэх ажил</b>	<b>Хяналтын чиглэл</b>	<b>Хугацаа</b>
1	Улсын төсөв, Зээл тусламж, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламж, их засвар шинэчлэлтийн ажил хийгдэж байгаа зам, замын байгууламжийн барилгын ажлын гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын гэрээний хэрэгжилтэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх	Авто зам	I-IV улирал
2	Булган аймгийн Сэлэнгэ сумын Сэлэнгэ мөрний 432.5 у/м төмөр бетон гүүрийн ажилд хяналт шалгалт хийх	Авто зам	I-II улирал
3	“АТҮТ” ТӨҮГ-ын орон нутаг дахь Автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэг, улс, хот хоорондын ачаа, зорчигч тээврийн үйл ажиллагаа болон тээвэрлэлт эрхлэгч байгууллагуудад хяналт шалгалт хийх/Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай/	Автотээвэр	I улирал
4	“Монголын төмөр зам” ТӨХК-д хяналт шалгалт хийх	Төмөр зам	3-р сар
5	“УБТЗ” ХНН-ийн Зам засварын машинт станцад хяналт шалгалт хийх	Төмөр зам	4-р сар
6	Улсын төсөв, гадаадын зээл тусламж болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж буй Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км, Увс аймгийн Наранбулаг сумын нутаг Хяргас нуурын зүүн хаяа-Сонгино сум чиглэлийн 135.5 км, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км, Баянхонгор-Говь-Алтай чиглэлийн 129 км, Багануур-Өндөрхаан чиглэлийн 45 км замын засварын шинэчлэлтийн ажилд хяналт шалгалт хийх, зөвлөмж өгөх	Авто зам	II-IV улирал
7	“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”-д хяналт шалгалт хийх	төмөр зам	5-р сар
8	Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт эрхлэгч “Петро Чайна Дачин Тамсаг Монгол” ХХК-д хяналт шалгалт хийх	Автотээвэр	II улирал
9	Дархан-Уул аймаг дахь “УБТЗ” ХНН-ийн Замын 1-р анги, Дохиолол холбооны 1-р анги, Зүтгүүрийн депогийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Төмөр зам	6-р сар
10	Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхэлж буй 13 аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт хийх	Автотээвэр	II улирал
11	“АТҮТ” ТӨҮГ, Улс болон хот хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын гэрээ дүгнэсэн байдалд хяналт тавих	Автотээвэр	6, 12-р сар
12	Усан замын тээврийн хэрэгслийг нэгдсэн тооллого, бүртгэл, техник-экологийн байдалд хяналт шалгалт хийх	Усан зам	III улирал
13	МХЕГ-тай хамтран улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт засварын ажлыг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	Авто зам	III улирал

14	МХЕГ-тай хамтран тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Автотээвэр	III улирал
15	Хөвсгөл нуурт /Ханх сум, Хатгал тосгон/ үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн усан замын тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн болон техник ашиглалтын байдалд хяналт шалгалт хийх	Усан зам	III улирал
16	Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км, Орхон аймгийн Эрдэнэт хотын Дэнж багт баригдах 5.08 км хатуу хучилттай авто замын үлдэгдэл болох 1.5 км, Цагаанхад-Гашуунсухайт чиглэлийн 18.6 км, Тосон-Уул XIX талбай-Баянхошуу боомт чиглэлийн 210.7 км авто замыг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах	Авто зам	Тухай бүр
17	Архангай аймгийн Тариат сумын Тэрхийн голын 217.1 у/м төмөр бетон гүүрийн их засварын ажлыг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах	Авто зам	Тухай бүр
18	“УБТЗ” ХНН-ийн Техникийн бодлого, зураг төслийн төвд хяналт шалгалт хийх	төмөр зам	10-р сар
19	“АТҮТ” ТӨҮГ-ын орон нутаг дахь Автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэг, улс, хот хоорондын ачаа, зорчигч тээврийн үйл ажиллагаа болон тээвэрлэлт эрхлэгч байгууллагуудад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх/Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай/	Автотээвэр	IV улирал
20	Төв, Говийн бүсийн Замын зурвас газар, аюулгүйн бүсэд баригдсан барилга байгууламж, объект нь тээврийн аюулгүй байдалд нөлөөлж байгаа эсэхийг шалгаж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах	Авто зам	12-р сар
21	Улсын чанартай зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг хангуулах, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, гарсан зөрчлийг бууруулах, аюулгүй байдлыг хангуулах	Авто зам	12-р сар
22	Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн албан шаардлагын дагуу гүйцэтгэлийн шалгалт хийх	Авто зам, Төмөр зам, Автотээвэр	II-IV улирал
23	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр, түүнчлэн осол аваар, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх		Тухай бүр
24	Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн албан шаардлагын дагуу гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх/“Бор-Өндөрийн УБҮ”, “Багануур” ХК, “Дулааны 4-р цахилгаан станц” ТӨХК, Хөтөлийн “Цемент шохой” ХК, “Эрдэнэт дулааны цахилгаан станц” ТӨХК, “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Шарын гол” ХК/	Төмөр зам	Тухай бүр
25	Төмөр замын тээврийн зарим объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх ажлын хэсэгт орж ажиллах, шаардлагатай бол шалгалт хийх	Төмөр зам	Тухай бүр

Байгууллага, иргэдэд зориулсан сургалт семинар, зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх, тандалт судалгааг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Гүйцэтгэх ажил	Хяналтын чиглэл	Хугацаа
1	Зам, тээврийн хяналтын улсын байцаагч нарыг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулах		I-II улирал
2	Усан замын тээвэр эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, завь жолоодогчдод холбогдох хууль, тогтоомж, аюулгүй ажиллагаа, аврах хантаазны ач холбогдол, байгаль орчныг хамгаалах талаар сурталчлан таниулах сургалт семинарыг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулах	Усан зам	II улирал
3	МХЕГ, “АТҮТ” ТӨҮГ-тай хамтран авто засвар, үйлчилгээ эрхлэгчдэд сургалт зохион байгуулах	Автотээвэр	6-р сар
4	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Төмөр замын цехийн үйл ажиллагаанд шалгалт хийж, дохиолол, холбоо, зүтгүүрийн чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	Төмөр зам	8-р сар
5	Гашуунсухайт чиглэлийн тээвэрлэгч байгууллагуудад “АТҮТ” ТӨҮГ, “Энержи ресурс” ХХК-тай хамтран Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах “Энержи ресурс” ХХК-ийн байранд “Аюулгүйн тээвэр-Хөдөлгөөний зохицуулалт, засвар үйлчилгээ” сэдэвт сургалт зохион байгуулах	Автотээвэр	8-р сар
6	Улсын чанартай зам замын байгууламжийн байнгын бэлэн байдал хариуцдаг байгууллагуудад мэргэжлийн болон хууль эрх зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	Авто зам	I-III улирал
7	МХЕГ-тай хамтран хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 8 байгууллагын үүсгэн байгуулсан “Авто тээврийн анхдагч групп” ХХК-д тандалт судалгаа хийх	Автотээвэр	9-р сар
8	МХЕГ-тай хамтран хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч Тамирын бугат ХХК, Хүслэнт ажнай ХХК-д мэргэжлийн болон хууль эрх зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	Автотээвэр	III улирал
9	Хөвсгөл аймгийн “Улаан загалмайн хороо”-той хамтран Хөвсгөл нуурын эрэг орчмын нутгийн иргэд, жуулчны баазуудын ажилчдад усанд осолдсон хүнд анхан шатны тусламжийг хэрхэн үзүүлэх дадлага, сургуулалтыг давтамжтайгаар зохион байгуулах	Усан зам	III улирал
10	2017 онд шинээр тээвэрлэлтийн гэрээ байгуулах, улсын дугаар үйлдвэрлэх аж ахуйн нэгж, байгууллагуудад дотоод хяналт хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	Автотээвэр	Тухай бүр
11	Стандартын шаардлагад нийцсан аврах хантаазыг байнга хэрэглэж хэвшүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллага иргэдэд сургалт сурталчилгаа зохион байгуулах	Усан зам	II-III улирал
12	Төмөр замын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын осол, гологдлоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих, гарсан осол, гологдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, зөвлөмж өгөх	Төмөр зам	Тухай бүр